

**НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ "ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ
НЭГ. САНАЛ БОЛОВСРУУЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖУУД		
А.ХУУЛИЙН ТӨСӨЛ Зорилго: <i>Дотоод аудитын эрх зүйн орчинг сайжруулах</i>		
1	Дотоод аудитын тухай хуулийн төсөлд санал боловсруулж өгөх	“Дотоод аудитын тухай хууль”-ийн төсөл, түүний үзэл баримтлал, холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг уншиж судлан 20 орчим саналыг боловсруулан Монгол Улсын Сангийн яам, НЗДТГ-ын ХЭЗХ-т хүргүүлсэн.
Б. ЗАХИРГААНЫ АКТЫН ТӨСӨЛ Зорилго: <i>Байгууллагын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох эрх зүйн орчинг сайжруулах</i>		
2	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж батлуулах	Байгууллагад бүтцийн өөрчлөлт хийсэн, байгууллагын дүрэм шинэчлэн батлагдсан, Засгийн газраас төсвийн хэмнэлтийн горимд шилжин, төсөв танагдсан зэрэгтэй болон бусад холбогдох хууль тогтоомжуудтай уялдуулан байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлж байна.
3	Шаардлагатай ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж боловсронгуй болгох	Зарим нэгжийн нэр, чиг үүрэгт өөрчлөлт орсон, зарим албан тушаал хасагдаж, нэмэгдсэн тул захиргааны хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, архив, бичиг хэргийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан батлуулж мөрдөн ажилласан.
4	Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдөх	Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж, комиссын дүрмийг байгууллагын дүрэмтэй нийцүүлэн байгууллагын даргын 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/15 тушаалаар шинээр баталж, ажлын төлөвлөгөө гарган ажилласан.
5	Байгууллагын архивын дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдөх	Байгууллагын архивын дүрмийг байгууллагын дүрэм, шинэчлэгдсэн бүтэцтэй уялдуулан шинэчлэн боловсруулж даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн, байгууллагын даргын 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/15 тушаалаар батлуулж мөрдөн ажилласан.
6	НДАА-ны даргын Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах	Байгууллагын даргын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг байгууллагын шинэчлэгдсэн бүтэцтэй уялдуулан даргын 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/17 тушаалаар батлуулж мөрдөн ажилласан.
7	Байгууллагын ёс зүйн дүрмийг боловсруулах талаар судалгаа хийх	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны ёс зүйн дүрэм, дотоод аудиторын ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмүүдийг судалж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Ёс зүйн дүрэм”-ийг шинээр боловсруулан мөрдүүлэхээр байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороо ажиллаж байна.
ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ Зорилго: <i>Эрх зүйн шинэтгэлийн ажилд албан хаагчдын оролцоог хангах, тэднийг татан оролцуулах</i>		

1	Байгууллагын удирдлагыг хуульд нийцсэн шийдвэр гаргахад мэргэжил, арга зүйгээр хангах, байгууллагын даргын тушаалд кодификаци хийх	2017 оны байдлаар байгууллагын даргын 62 тушаалыг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын холбогдох заалтуудад нийцүүлэн гаргасан. Байгууллагын архивын сан хөмрөгт хадгалагдаж буй байгууллагын захирамжлалын цаасан болон цахим 11 баримтад кодификаци хийн, бүртгэл хөтөлж, зохих тэмдэглэгээг хийсэн.
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай нь шүүхээс тогтоогдсон албан тушаалтнаар буцаан төлүүлэх асуудлыг хариуцах, шаардлагатай тохиолдолд хууль, шүүхийн байгууллагад төлөөлөл хэрэгжүүлэх	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.04.18-ны өдрийн хуралдаанаар Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын буруутай шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг тухайн байгууллагаар төлүүлэхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг биелүүлж, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу буруутай этгээдээр буцаан төлүүлэх асуудалд хяналт тавьж ажилласнаар хохирлыг бүрэн барагдуулсан.
3	НЗДТГ-ын ХЭЗХ-ээс зохион байгуулах сургалт, семинарт оролцох	НЗДТГ-ын ХЭЗХ, ХЗЯамны хамтарсан Зөрчлийн тухай хуулийн сургалтад санхүүгийн хяналт шалгалтын 6 байцаагч, Захиргааны ерөнхий хуулийн ахисан түвшний сургалтад 2 албан хаагч оролцож, Нийслэлийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал солилцсон.
4	Албан хаагчдад эрх зүйн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу ахлах аудитор С.Цолмон аудиторын сургалт, Захиргааны хэлтсийн дарга Я.Сарансүх хуульчийн үргэлжилсэн сургалт, архив, бичиг хэргийн ажилтан Б.Мягмардулам архив, бичиг хэргийн мэргэжлийн сургалтад, СЯ-ны Дотоод аудитын эрчимжүүлсэн сургалтад 3 албан хаагч, Дотоод аудитын сургалт, АТГ-т хүсэлт гаргаснаар Авлигын эсрэг хууль тогтоомж, төрийн албан хаагчдын ёс зүйн сургалтад 17 албан хаагчийг, НЗДТГ-аас зохион байгуулсан Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ны сургалт, "Виз болон гадаад паспорт олгох эзэмших, хадгалах тухай журам", байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулан "Ёс зүй-Сахилга хариуцлага" сургалтад байгууллагын дарга Б.Жавзан, НАГ-ын "Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" онлайн сургалт зэрэг төрөл бүрийн сургалтуудад албан хаагчдыг хамруулсан. Авлигын эсрэг сургалтын материалуудыг байгууллагын цахим хуудсаар болон албан хаагчдын цахим хаягаар илгээн танилцуулж, авлигын эсрэг зурагт хуудсуудыг байгууллагын самбар дээр байнга байршуулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилсан.

ХЯНАСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ